



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 06 өдөр

Дугаар А/23

Ховд

Төсөл сонгон шалгаруулалт
зохион байгуулах тухай

Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт, 2017 оны 347 дугаар тогтоолоор баталсан Ховд хотыг 2030 он хүртэл хөгжүүлэх төлөвлөгөө, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 5/09 дүгээр тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2010 оны 267 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Жаргалант сум Тахилт баг Шинэ суурьшлын бүсэд 4 га газарт газар эзэмшүүлэх төсөл сонгон шалгаруулалтыг 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдөр зохион байгуулж явуулсугай.

2. Төсөл сонгон шалгаруулалтаар эзэмшүүлэх газрын байршил, хэмжээг хавсралтаар баталсугай.


3. Газар эзэмшүүлэх төсөл сонгон шалгаруулалтанд оролцох хүсэлтэй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын холбогдох материалыг хуулийн дагуу бүрдүүлэх, хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарлах, холбогдох бэлтгэл ажлыг хангаж ажиллахыг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар /Э.Дөлбадрал/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Аймгийн Засаг даргын 2022 оны
01 дүгээр сарын 06-ны өдрийн
А/23 дугаар захирамжийн хавсралт



ТӨСӨЛ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТААР ОЛГОХ
ГАЗРЫН БАЙРШИЛ, ХЭМЖЭЭ

Д/д	Байршил	Эзэмших хугацаа	Хэмжээ /га/-аар	Зориулалт
1.	Жаргалант сум Тахилт баг Шинэ суурьшлын бүсэд	15	0.4	Орон сууцны
2.	Жаргалант сум Тахилт баг Шинэ суурьшлын бүсэд	15	0.4	Орон сууцны
3.	Жаргалант сум Тахилт баг Шинэ суурьшлын бүсэд	15	0.4	Орон сууцны
4.	Жаргалант сум Тахилт баг Шинэ суурьшлын бүсэд	15	0.4	Орон сууцны
5.	Жаргалант сум Тахилт баг Шинэ суурьшлын бүсэд	15	0.4	Орон сууцны
6.	Жаргалант сум Тахилт баг Шинэ суурьшлын бүсэд	15	0.4	Орон сууцны
7.	Жаргалант сум Тахилт баг Шинэ суурьшлын бүсэд	15	0.4	Орон сууцны
8.	Жаргалант сум Тахилт баг Шинэ суурьшлын бүсэд	15	0.4	Орон сууцны
9.	Жаргалант сум Тахилт баг Шинэ суурьшлын бүсэд	15	0.4	Орон сууцны
10.	Жаргалант сум Тахилт баг Шинэ суурьшлын бүсэд	15	0.4	Орон сууцны

-оОо-